

БУРИАДЫН ГАДААД ЭДИЙН ЗАСГИЙН ТЭРГҮҮЛЭХ БАЙР СУУРЬ (Эрэл, хэтийн төлөв)

Түүхийн ухааны доктор
Ц.Ганжуров (Орос.Буриад)

Зах зээлийн харилцаанд шилжих нөхцөлд гадаад эдийн засгийн үйл ажиллагааг либералчлах нь эдийн засгийн хөгжлийн асуудлыг шийдвэрлэхэд Оросын зарим бүс нутгийн олон улсын хэлхээ холбоо чухал үүрэг гүйцэтгэх болов. Холбооны субъектын олон улсын үйл ажиллагааны хэлбэр олон талт бүхий л чиглэлийг газарзүй, агуулга, зохион байгуулалтын гэсэн 3 үндсэн талаас нь авч үзэж болох юм.

Газар зүйн хувьд, Буриад нь Оросын гадаад бодлогын Азийн чиглэлийн гол үзүүрт учраас ашигтай байдалтай юм. Сүүлийн жилүүдэд дэлхийн олон оронтой, юуны өмнө Ази-Номхон далайн бүс нутгийн орнуудтай маш идэвхитэй харилцаа бүхий Монгол улстай Буриад шууд хиллэдэг. Дорно, Өрнийг холбосон авто, төмөр замын гол шугам Буриадын нутаг дэвсгэрийг дамжин өнгөрдөг ба мөн Бүгд Найрамдах Улсын нутагт орших дэлхийд хосгүй Байгаль нуур олон улсын аялал жуулчлалыг хөгжүүлэхэд өргөн хэтийн төлөв нээн өгч байна.

Бүгд Найрамдах Улсын гадаад харилцааны агуулгын тухайд гэвэл, энэ нь дийлэнхийдээ эдийн засгийн шинж чанартай юм. Ийм харилцаа нь бараа таваар экспортлох боломжийг эрж хайх, гадаадын жуулчдыг татах, мөн гадаадын хөрөнгө оруулалтыг олж авах гурван зүйлд төвлөрдөг. Түүнчлэн боловсрол, шинжлэх ухаан, соёл, хүрээлэн буй орчины гэх мэт салбарт хамтран ажиллах явдал чухал ач холбогдолтой нь маргаангүй билээ. Гэлээ ч Бүгд Найрамдах Улсын эдийн засаг ядуу зүдүү байгаа нөхцөлд гадаад эдийн засгийн харилцаа илтэд хоцорч байна.

Бүгд Найрамдах Улсын гадаад эдийн засгийн үйл ажиллагааны үлэмж олон янз зохион байгуулалтын хэлбэрийг шууд ба дам гэж хувааж болно. Шууд гэдэгт нь юуны өмнө гэрээ хэлэлцээний үндсэнд тулгуурласан үйл ажиллагаа, хамтарсан үйлдвэр байгуулах, олон улсын худалдааны бүс, бусад орон гадаадын фирмүүдтэй шууд холбоо тогтоох] гэх мэтийг оруулж болно. Дам гэдэгт нь 29 сая хүн ам, 6 сая км² бүс нутгийг хамарсан "Сибирское соглашение" ("Сибирийн хэлэлцээ") нэгдэл, "Дальний Восток и Забайкалье" ("Алс Дорнод ба Байгалийн чанад") программ, Сибирь, Алс Дорнод ба БНСУ-ын хоорондын хамтын ажиллагааны Ассоциаци зэргийн үйл ажиллагаан дахь Буриадын

оролцоог хэлж болно. Үүнээс гадна Ази-Номхон далайн бүс нутгийн улсуудын интеграцчилалын нөхцөлд хэрэгжүүлж буй олон улсын эдийн засгийн хэд хэдэн төсөлд Буриадын үүрэг, эзлэх байр суурь чухал ач холбогдолтой юм.

Иймээс ч энэ бүх зүйлс нь Бүгд Найрамдах Улсын гадаад эдийн засгийн үйл ажиллагаанд тодорхой ул мөрөө үлдээхийн зэрэгцээ Буриадын геополитикийг иш үндэс болгон зохион байгуулалтын шинэ хэлбэрийг эрж хайх, агуулгыг боловсронгуй болгоход тус дөхөм болж байна.

Буриадын Бүгд Найрамдах Улс гадаад хөрөнгө оруулалтыг татдаг бүс нутгийн төсөлд ордоггүй ч гадаадын хөрөнгө оруулалтыг татах гадаадын фирмүүдтэй худалдаа-эдийн засгийн харилцаагаа хөгжүүлэх тодорхой оролдлого хийж байна. Урт хугацааны хөрөнгө оруулалтыг татах, худалдаа-эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх үр ашигтай хэлбэрийн нэг нь эдийн засгийн чөлөөт бүс байгуулах явдал мөн. Эдийн засгийн шинэтгэлийн эхний үе шатандаа хэд хэдэн эдийн засгийн бүс, далайн эрэг орчимын нээлттэй боомт хот байгуулсан Хятадын туршлага дэлхийн практикт сонирхолтой юм. Одоо Манжуур-Байгалийн чанадын район дахь "Умарт Гонконг" гэж нэрлэгддэг "Байгалийн чанад дахь эдийн засгийн чөлөөт бүс"-ийг барьж байгуулах ажлыг идэвхитэй боловсруулж байна. Зөвхөн Хятадын "Наньдэ" корпорациас энэ районы дэд бүтцийн байгууламжинд оруулж буй нэмэлт хөрөнгө оруулалт 400 сая долларт хүрч байна.

Орост хэд хэдэн ийм бүс амжилттай ажиллаж байгаа бөгөөд, гадаад ертөнцтэй байнгын тасралтгүй холбоо тогтооход зайлшгүй шаардагдах объектуудыг байгуулж буй эдийн засгийн тусгай бүс "Находка" бол Буриадын хувьд үлгэр жишээ болох юм.

Буриадад худалдааны хэлбэртэй гаалийн хоёр бүс байгуулах оролдлого хийж байна. Энэ нь "Кяхта", "Аэрофорт г.Улан-Удэ" гэсэн худалдааны чөлөөт бүсүүд болно. Хиагтад гаалийн бүс байгуулах санаа хуучин уламжлал, гүнзгий үндэстэйг тэмдэглэх хэрэгтэй. Учир нь бүр ХҮИ-ХХ зууны эхээр чухамдаа Хиагт хот Хятад, Монголтой "худалдаа арилжаа хийх" төв болж байв. Бүр 1911-1912 онд Оросын сангийн яамны сайд В.Н.Кокоцев, Гадаад явдлын Яамны сайд С.Д.Сазонов нар Орос зуучлан барууны фирмүүдийн тусламжтайгаар Монголд Оросын экспортыг нэмэгдүүлэх асуудлыг тухайлан авч үзсэн Монголын программ гэдгийг тусгайлан боловсруулжээ. Ингэвэл Орос улс элдэв төрлийн хямд бүс бараа, аж үйлдвэрийн бусад бүтээгдэхүүнийг Монголд нийлүүлэх өвөрмөц маягийн "баруун" болж чадах байлаа. Гэвч өнөөдрийн байдал харин ч бүр эсрэгээр байна. Чухамдаа Орос орон бусад оронд өрсөлдөх чадваргүй, хямд барааг борлуулах асар том зах зээл болчихоод байна. Ийм нөхцөлд Оросын иргэд бусад орны эдийн засагт ямар нэг хэмжээгээр хөрөнгө оруулагч болох болгоомжлол төрж байна.

Орост "чөлөөт эдийн засгийн бүсийн тухай" холбооны улсын хууль гараагүй байхад Монголд 1996 оны эцсээр "Алтан булагийн эдийн засгийн чөлөөт бүс" байгуулах тухай хууль батлагдсан байв.

Оросын Холбооны Улсын хууль гараагүй цагт "Хиагт-Алтанбулагийн эдийн засгийн чөлөөт бүс"-ийн үйл ажиллагааг эхлэх боломжгүй юм.

Сибирь, Монголыг дамнасан төмөр замыг ашиглах талаар Хятадтай удаан хугацааны төлөвлөгөөтэй ажиллаж байгаа болон Хятадын хилээс Монголыг дайруулан Оросын хил хүртэл автозам байгуулж байгаатай холбогдон Бүгд Найрамдах Улсын өмнө өргөн их боломж нээгдэж байна. Монголыг дамнасан төмөр зам болон баригдаж буй авто замаар тээвэрлэх ачаа барааг нэмэгдүүлэх нь Буриадыг "цайны их зам" биш, харин Хятадаас европ хүрэх "зангилаа их зам" болоход хүргэнэ гэж Хятад, Монголын тал тооцоолж байна.

Буриадын хувьд, Бүгд Найрамдах Улсын ашиг сонирхлыг ямар нэг хэмжээгээр хөндсөн олон улсын зарим том төсөлд оролцох сонирхол ихтэй байна. Ийм сонирхол нь Оросоос Япон, Хятад, Өмнөд Солонгостой эдийн засгийн хамтын ажиллагаа явуулахад Буриад гүүр болж чадна гэдэгт тулгуурлаж байна. Тэгээд ч Орос, Хятад хоёр жил бүр Хятадад 25 тэрбум шоо метр байгалийн хий нийлүүлэх, Эрхүү муж дахь Ковыткины байгалийн хийн орд газрыг хамтран эзэмшиж эхлэх талаар тохиролцоод байгаа билээ. Ямар ч нөхцөлд Бүгд Найрамдах Улсыг байгалийн хийгээр хангаж чадах хий дамжуулах хоолой Буриадын нутаг дэвсгэрийг дайрч өнгөрөх бөгөөд үүнд зориулж Буриадын Засгийн газар Байгалийн чанадыг байгалийн хийгээр хангах сан байгууллаа. Үүнээс гадна, хий дамжуулах хоолой нь Бүгд Найрамдах Улсад ажлын шинэ байр бий болгох, татвар оногдуулах бааз суурийг өргөтгөх, сургуулиудад тусгай мэргэжлийн боловсон хүчин бэлтгэхэд туслана.

Сибирийн цахилгаан станцуудын илүүдэл эрчим хүчийг худалдаалах эрчим хүчний томоохон төслүүдэд Буриад оролцож болно. Тухайлбал, Богучаны Усан цахилгаан станцын барилга байгууламж дууссаны дараа Хятад улс, Эрхүү муж, Красноярскийн хязгаараас жил бүр жилдээ 40 тэрбум квт цаг эрчим хүч авч байх юм. Энэ нь Буриадад тодорхой хэмжээгээр Орост болж буй интеграцийн процесст оролцох, улмаар одоо дэлхийн эдийн засгийн идэвхитэй үйл ажиллагааны төв шилжиж буй Ази-Номхон далайн бүс нутгийн орнууд дахь интеграцитай ямар нэгэн хэмжээгээр холбогдох боломж олгоно.

Буриадын гадаад эдийн засгийн үйл ажиллагааг боловсронгуй болгохын тулд Оросын явуулж буй олон улсын үйл ажиллагаанд Буриадын оролцох программ боловсруулах ажлыг идэвхжүүлж, олон асуудлыг шийдвэрлэхэд ихээхэн идэвхи, санаачилга гаргах хэрэгтэй байна. Тэгээд ч Монголын ард түмний хэд хэдэн үе ЗХУ-ын өргөн

хэрэглээний барааг хэрэглэж дадсан учраас сүүлийн жилүүдэд хөрш Монгол Улсад Оросын үйлдвэрлэлийн барааны эрэлт өслөө. Ийм нөхцөлд “Хиагт-Алтанбулагийн эдийн засгийн чөлөөт бүс” байгуулах шийдвэрийг өөрийн үйлдвэрийн бараагаа борлуулах худалдааны төв байгуулах тухай асуудалтай хамт боловсруулан шийдэх нь зүйд нийцэхсэн билээ. Тэгвэл, Монголын тал Улаан-Үдийн Шувуу фабрик, Мебелийн үйлдвэр, хүнсний “Амта” үйлдвэрийн бараа бүтээгдэхүүнийг худалдан авахыг сонирхоно гэж бид бодож байна.

Олон улсын шинжлэх ухаан-техник, соёлын хэлхээ холбоог өргөнөөр хөгжүүлэх ажилд Буриад санаачлагатай оролцож болно.

Өнөөдөр шинжлэх ухааны чадавхиар Буриад нь гагц Новосибирск, Томск гэсэн нийтээр хүлээн зөвшөөрсөн шинжлэх ухааны төвүүдийн дараа Сибирьт голлох байр эзэлж байна. Тэгээд ч оюуны өмч нь үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээс багагүй, зарим тохиолдолд бүр ч илүү их ашигтай, чухал ач холбогдолтой байдаг.

Үүнээс гадна, Буриад нь хуучин ЗХУ-ын өрийн асуудлаар, тухайлбал хөрш Монголын өрийн асуудлаар боломжийн хирээр Оросын төлөөлөгчийн үүрэг гүйцэтгэж болох юм. Энэ нь өрөнд тооцож Монголоос мах авч, Махкомбинатад дахин боловсруулаад Оросын бусад бүс нутгуудад борлуулах боломж олгоно.

Үйлдвэрлэлийн хоршоолол, шинжлэх ухаан техникийн хамтын ажиллагаа, барилгын худалдаа, тээврийн үйлчилгээ, олон улсын лизинг зэрэг дэлхий нийтээр зөвшөөрсөн эдийн засгийн хамтын ажиллагааны арга, хэлбэрийг Буриад улам бүр идэвхитэй ашиглавал зохино.

Чингээд, Бүгд Найрамдах Улсын гадаад эдийн засгийн үйл ажиллагааг амжилттай явуулж ашигтай ажиллахын тулд Оросын ба дэлхийн хөгжлийн тогтвортой хандлагыг харгалзсан шинжлэх ухааны үндэстэй программ хэрэгтэй.

PS: Энэ өгүүлэл нь 1998 оны 6-р сард Улаанбаатар хотноо болсон “Зүүн хойт Азийн эдийн засгийн хамтын ажиллагаа” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний бага хуралд тавьсан илтгэл болно.

Орос хэлнээс орчуулсан Л.БЭГЗЖАВ